

БАТЛАВ:



Д.ЖАМБЯНШАРАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**ЮНИТЕЛ ХХК-ИЙН СҮЛЖЭЭ ХООРОНД
ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү нөхцөлийг Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид “ХХЗХ” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолоор баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам (цаашид “Журам” гэх)-ыг үндэслэл болгон сүлжээний харилцан холболт хийх үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.
- 1.2 Энэхүү нөхцөлөөр Юнител ХХК (цаашид “Юнител” гэх) нь хууль ёсны тусгай зөвшөөрөл бүхий хүсэлт гаргагч (цаашид “Хүсэлт гаргагч” гэх)-ийн (хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) сүлжээ хооронд харилцан холболт хийх, зааглах цэгийн байршил, гэрээ байгуулах, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Юнител нь сүлжээ хооронд харилцан холболт хийх тухай Хүсэлт гаргагчдад ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтална.
- 2.2 Юнител нь сүлжээ хооронд харилцан холболт хийхэд нээлттэй сүлжээний стандартыг хангах зарчмыг баримтална.
- 2.3 Юнител нь харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (цаашид “Нөхцөл” гэх) боловсруулан ХХЗХ-оор хянуулан баталж өөрийн цахим хуудсандаа байршуулна.
- 2.4 Энэхүү журамд ашигласан нэр томъёог MNS ITU-T R Q.9:2004, MNS ITU-T R.E.600:2004 стандартуудад зааснаар ойлгоно.
- 2.5 Талууд сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулах, орлого хуваарилах зарчим, төлбөрийн хэмжээг тогтоохдоо аливаа бизнесийн алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй.
- 2.6 Талууд өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүй улмаас сүлжээ хооронд харилцан холболт хийсэн эсхүл сүлжээнд нь холбогдсон харилцаа холбооны үйлчлэгчид үүссэн хохирлыг буруутай тал хариуцна.
- 2.7 Сүлжээ хооронд харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх нөхцөлд ХХЗХ-ны 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 33 тоот тогтоолоор батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.11 дэх заалтыг баримтална.

ГУРАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

- 3.1 Хүсэлт гаргагч нь харилцан холболт хийхэд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 22 дугаар зүйл болон ХХЗХ-ноос баталсан холбогдох журмыг баримтлж, гэрээ байгуулна.
- 3.2 Хүсэлт гаргагчийн техник, төхөөрөмж нь Үндэсний болон Олон улсын стандартын (MNS 5382:2004, ITU-T Q.761, ITU-T Q.767, 3GPP Release 11, 3GPP TS23.231, TS29.231, TS29.235, TR23.228 V11 or above) шаардлагыг хангасан Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн

байгууллагаар баталгаажуулагдсан, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх бусад сүлжээтэй харилцан холбогдох техникийн нөхцөлийг бүрэн хангасан байна.

- 3.3 Хүсэлт гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байна. Хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална ба дараах KPI үзүүлэлтийг хянадаг байна. Үүнд:
- а) Холбох шугамын багтаамж ашиглалт (Trunk Usage)
 - б) Амжилттай холболт тогтолтын хувь (Technical Completion Ratio)
 - в) Амжилтгүй холболт тогтолтын хувь (Unsuccessful Call Ratio)
- 3.4 Талууд өөрийн үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй ба ямар нэг маргаан гарсан тохиолдолд ХХЗХ-г технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг тогтоох зорилгоор нэвтрүүлж техник, тоног төхөөрөмжид хэмжилт, хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл програм хангамжаар хангана.
- 3.5 Хүсэлт гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн угсралт болон кабель шугамын суурилуулалтыг хийж гүйцэтгэхдээ энэ талаар батлагдан гарсан Үндэсний стандарт, норматив баримт бичгийг мөрдөж ажиллах ба хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээнд ашиглагдахаар байгуулсан сүлжээний найдвартай ажиллагаа, инженер техникийн ажилтны аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан байна.
- 3.6 Хүсэлт гаргагч нь ярианы үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дээрх стандартыг хангасан холболтын байгууламж (soft switch, gateway, router), төлбөр тооцооны систем (billing system), зай тэжээлийн төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын систем (network management system)-ийг ашиглана.
- 3.7 Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан холболтын байгууламжтай байна. Үүнд:
- 3.7.1 Ярианы болон бусад холбогдох протоколууд ба кодыг дэмжих, тэдгээрийн хувиргалт, шилжилтийг хийдэг байх;
 - 3.7.2 Ярианы төлбөрийг секундын нарийвчлалтай тооцох боломжтой байх;
 - 3.7.3 Эцсийн хэрэглэгчийн яриаг эхлүүлэх болон төгсгөх;
 - 3.7.4 Бусад сүлжээтэй PU-T G.703 стандартын дагуу E1 болон IP холбох шугамаар холбогдох.
- 3.8 Хүсэлт гаргагч нь хуурамч дуудлага, дугаараа өөрчилж залгасан дуудлага, спам мессеж, дуудлагыг (spoof call, sim box detection, long call alerting, traffic volume assurance, telemarketing, spam messaging) илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх техник, тоног төхөөрөмжийн боломжийг бүрдүүлсэн байнгын хяналт хийж ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- 3.9 Хүсэлт гаргагч нь орох дуудлагын хувьд ОУЦХБ-ын E.164-ийн дагуу дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулдаг (CLI-Calling Line Identification) байна.
- 3.10 Сүлжээ хооронд харилцан холболт хийх горимд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлийг аль нэг тал нь санаачлан хийх бол 3 сараас доошгүй хугацааны өмнө өөрчлөлт хийх талаарх мэдээлэл, үндэслэл, шаардагдах техникийн нөхцөлийг нөгөө талд мэдэгдэн тохиролцох ба энэ талаар ХХЗХ-нд мэдэгдэнэ.
- 3.11 Хүсэлт гаргагч нь SIP харилцан холболтны хувьд өөрийн үндсэн байранд зааглах цэггүй, гуравдагч байгууллагын зааглах цэгээр харилцан холбогдож байгаа тохиолдолд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс TLS протоколыг ашиглана. Харин зааглах цэг нь харилцан холбогдож байгаа 2 байгууллагын аль нэгийг нь тохиолдолд TLS ашиглахгүй.
- 3.12 Сүлжээний найдвартай байдлыг хангаж active/active эсвэл active/standby байдлаар нөөц холболтыг хангаж Layer 3 холболт хийнэ.

ДӨРӨВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

- 4.1 Сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7, 22.3 заалт болон ХХЗХ-ны *Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага*-д заасны дагуу тодорхойлно.
- 4.2 Юнител нь өөрийн сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн Хавсралт 1-д заасан ба энэ талаар *Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ*-нд нарийвчлан тусгана.
- 4.3 Талууд зөвхөн ХХЗХ-ноос тогтоосон зааглах цэгт сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээг үзүүлнэ.
- 4.4 Хэрэв Хүсэлт гаргагч нь энэхүү нөхцөлийн Хавсралт 1-д зааснаас өөр байршилд сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг тогтоолгох, холбох хүсэлт гаргавал Юнител нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөл боломж байгаа эсэхийг судалж, тодорхойлно.
- 4.5 Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг бүрдүүлж, хангана.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1 Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.
- 5.2 Талууд нь сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээгээр үзүүлж буй үйлчилгээний чанарын шаардлагыг энэхүү нөхцөлийн 5.1-д заасны дагуу зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний хувьд хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
- 5.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцож гэрээнд тусгах ба үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

ЗУРГАА. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ОРЛОГО ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ

- 6.1 Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хууль, ХХЗХ-ны 2011 оны 23-р тогтоолын хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 6.2 ХХЗХ өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалгаалан өртгөө нөхсөн байна.
- 6.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд тусгагдах сүлжээ хоорондын харилцан холболт хийх төлбөр болон сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний орлого хуваарилах зарчмын талаар эцэслэн тохирсон саналыг, хэрэв эсрэг байр суурьтай байх тохиолдолд тус тусын саналыг үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 өдрийн өмнө ХХЗХ-нд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 6.4 ХХЗХ-ноос сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулахаас өмнө болон гэрээний үргэлжлэх хугацааны дундуур сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилах зарчмын талаар шийдвэр гаргасан тохиолдолд Талууд шийдвэрийг гэрээнд шууд тусган дагаж мөрдөх үүрэгтэй.

ДОЛОО. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 7.1 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг энэхүү нөхцөлийн Хавсралт 4-т заасны загварын дагуу зөвхөн бичгээр, Монгол хэлээр байгуулна.
- 7.2 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор уг гэрээ болон түүний хавсралтын хуулбарыг, холбогдох баримт бичгийн хамт ХХЗХ-нд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ.
- 7.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг хүлээн авах, холболт гүйцэтгэх, гэрээ байгуулах үйл явц нь энэхүү нөхцөлийн Хавсралт 3-т заасан процессын дагуу хийгдэнэ.

НАЙМ. БУСАД

- 8.1 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, энэхүү журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг зорих бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 31.2 заалтын дагуу ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 8.2 Маргалдагч талууд ХХЗХ-ноос гаргасан шийдвэрийг хүлээж авахыг эрмэлзэх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

– о О о –



ЗААГЛАХ ЦЭГ, ХОЛБОЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Юнител
Холболтын байгууламжийн төрөл, марк	SE2980 UMG8900
Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк	NE8000, MPLS Router
Холбох шугамын төрөл, марк, багтаамж	20Gb
Интерфейсийн төрөл	STM-1, GE, 10GE
Зааглах цэгийн тоног төхөөрөмж	NE8000


ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил
Зааглах цэг 1-ийн байршил	Цахилгаан холбоо 2-р давхрын серверийн өрөө
Зааглах цэг 2-ийн байршил	Мобиком ХХК-ийн техникийн байр, 1-р давхар, 108 тоот
Зааглах цэг 3-ийн байршил	Скайтел ХХК-ийн техникийн байр, 2 давхар, серверийн өрөө

– о О о –



ЗААГЛАХ ЦЭГИЙН ЗУРАГЛАЛ



**СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ**

Д/д	Үйл ажиллагаа	Баримтын нэр, хийгдэх хугацаа
1.	Сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлт гаргагч нь хүсэлтээ бичгээр Юнителд гаргана.	Албан тоотоор хүсэлтээ ирүүлнэ
2.	Хүсэлт гаргагч нь дараах баримтыг албан тоотын хамт ирүүлнэ. Үүнд: 1. Компанийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 2. ХХЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар; 3. ХХЗХ-той байгуулсан дугаарлалтын гэрээ, холбогдох шийдвэр; 4. Холболтын байгууламжийн төрөл, холболтын санал, хамтран ажиллах техникийн болон гэрээ хариуцсан ажилтнуудын утасны дугаар, и-мэйл хаяг;	Албан тоотын хамт ирүүлэх баримт
3.	Юнител нь хүлээж авсан баримтын иж бүрдэл бүрэн эсэх, хүчинтэй хугацаа зэргийг хянаж, шалгах	Хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 5 өдөр
4.	Баримт бичгийн иж бүрдэл дутуу, холбогдох мэдээлэл дутуу ирсэн үед энэ талаар хүсэлт гаргагч руу мэдэгдэнэ.	Хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 10 өдөр
5.	Баримт бичгийн иж бүрдэл, холбогдох мэдээлэл бүрэн бол техникийн боломжийг судалж, техникийн шийдлийг гаргах, хүсэлт гаргагчтай техникийн шийдлийг тохирох. Шийдлийг баталгаажуулсны дараа дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: 1.1 Харилцан холболтыг хийж гүйцэтгэх; 1.2 Холбогдох тестийг талууд хамтран хийж гүйцэтгэх; 1.3 Тестийн үр дүнг протокол үйлдэж баталгаажуулна.	Техникийн шийдэл гарснаас хойш ажлын 30 өдөр
7.	Сүлжээ хооронд харилцан холболтын гэрээний төслийг Юнител талаас бэлтгэн хүсэлт гаргагчийн ирүүлсэн и-мэйл хаягаар илгээнэ.	Протокол хүлээн авснаас хойш ажлын 5 өдөр
8.	Гэрээний нөхцөл тохирч, холбогдох саналуудаа тусгаж гэрээний төслийг эцэслэж батлуулна.	Гэрээний төсөл хүлээн авснаас хойш ажлын 30 өдөр
6.	Харилцан холболтын гэрээний нөхцөлд талууд санал нэгдээгүй, эсрэг байр суурьтай байх тохиолдолд гэрээний 6.3-т заасны дагуу ХХЗХ-нд хүргүүлнэ.	Шинэчлэн байгуулахаас ажлын 21 өдрийн өмнө

9.	Гэрээг 3 (гурав) эх хувь үйлдэж батлах ба тал тус бүр нэгнийг, Юнител нь үлдэх нэг хувийг ХХЗХ руу хүргүүлнэ.	Гэрээ батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор
10.	Гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, энэхүү журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг гэрээтэй холбоотой маргаантай асуудлыг гэрээний 8.1-т заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.	Тухай бүр



ЮНИТЕЛ ХХК БОЛОН [•] ХХК-ИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

20[•] оны [•]-р сарын [•]-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас Юнител ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал [•] (цаашид “Юнител” гэх)

Нөгөө талаас [•] ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал [•] (цаашид “[•]”, Юнител болон [•] нарыг хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) нар нь

Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Монгол Улсын Харилцаа холбооны тухай, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомж, Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “ХХЗХ” гэх)-ноос харилцан холболтын талаар баталсан журмуудыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Талууд өөрийн сүлжээний хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор нөгөө талын сүлжээтэй харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3 Талууд ХХЗХ-ноос баталж гаргасан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам” болон харилцаа холбооны үйлчилгээнд мөрдөгдөх бусад холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага, баримт бичгийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Энэхүү гэрээний хүрээнд талууд доор дурдсан харилцан холболтын үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 1.4.1 Дотоод дуудлага хүлээн авах
 - 1.4.2 Дотоод дуудлага хийх
 - 1.4.3 Улс хоорондын дуудлага хүлээн авах
 - 1.4.4 Улс хоорондын гарах дуудлага хийх
 - 1.4.5 Дотоод мессеж бичих
 - 1.4.6 Дотоод мессеж хүлээн авах
- 1.5 Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах транзит үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 1.5.1 Дуудлага дамжуулах;
 - 1.5.2 Мессеж дамжуулах;
- 1.6 Талууд дотоодын бусад компаниудын харилцан холболтын ачааллыг өөрийн сүлжээгээр дамжуулан холболт хийх (транзит хийх) тохиолдолд талуудын нөгөө талтай байгуулсан харилцан холболтын гэрээг үндэслэл болгоно.
- 1.7 Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх ба эдгээр хавсралт нь гэрээний салшгүй нэгэн хэсэг байна.
 - 1.7.1 Хавсралт 1. Харилцан холболт хийх техникийн үзүүлэлтүүд, зааглах цэгийн байршил;
 - 1.7.2 Хавсралт 2. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал;
 - 1.7.3 Хавсралт 3. Талуудын сүлжээний дугаарлалт;
 - 1.7.4 Хавсралт 4. Харилцан холболтын үйлчилгээний тариф;
 - 1.7.5 Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтны мэдээлэл

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар гэрээ [•] оны [•] дүгээр сарын [•]-ний өдрөөс эхлэн [•] жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 2.2 Гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө талууд гэрээг цуцлах, шинэчлэх санал гаргаагүй тохиолдолд гэрээ нь цаашид ижил нөхцөл, ижил хугацаагаар нэг удаа сунгагдана.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Талууд доор дурдсан эрхийг эдэлнэ.
 - 3.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
 - 3.1.2. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах, гэрээнээс татгалзах, цуцлах, дуусгавар болгох тухай санал гаргах;
 - 3.1.3. Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
 - 3.1.4. Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах;
 - 3.1.5. Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулан авах;
 - 3.1.6. Гэрээний хэрэгжилтэд харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах.
- 3.2. Талууд доор дурдсан үүргийг хүлээнэ.
 - 3.2.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн бүхий л үүргээ шударгаар, бүрэн биелүүлэх;
 - 3.2.2. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх;
 - 3.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талынхаа бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 3.2.4. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх;
 - 3.2.5. Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх;
 - 3.2.6. Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол ХХЗХ-нд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний хэрэглэгчид болон харилцан холбогч нөгөө талд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
 - 3.2.7. ХХЗХ болон салбарын эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрийг чанд мөрдөж ажиллах.

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 4.1. **Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт**
 - 4.1.1. Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-т заасны дагуу байх ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгана.
 - 4.1.2. Сүлжээ хоорондын дохиолол ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгаж байна.
 - 4.1.3. Сүлжээ хоорондын дохиолол нь SIP, SS7 байх ба SIP дохиолол ашигласан тохиолдолд дамжуулалтын протокол нь TLS/SRTP байна.
 - 4.1.4. Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.
 - 4.1.5. Сүлжээний найдвартай байдлыг хангаж active/active эсвэл active/standby байдлаар нөөц холболтыг хангаж Layer 3 IP холболт хийнэ.
- 4.2. **Зааглах цэг**
 - 4.2.1. Сүлжээний зааглах цэгийн байршил Хавсралт 1-д заасны дагуу байна.
 - 4.2.2. Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
 - 4.2.3. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.

- 4.2.4. Талууд зааглах цэгээс хоёр тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

4.3. Сүлжээний ачаалал

- 4.3.1. Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
- 4.3.2. Нэгж шугамд ноогдох ачааллын хэмжээг 0.65 Эрлангаас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 4.3.3. Талуудын сүлжээнд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг гурван сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

4.4 Дугаарлалт

- 4.4.1 Талуудын сүлжээний дугаарлалт нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон дугаарлалтын хүрээнд Хавсралт 3-т заасны дагуу байна.
- 4.4.2 Талууд сүлжээний дугаарлалтыг Сүлжээний дугаарлалтын төлөвлөгөө, Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон зориулалтын дагуу зөвхөн хувь хэрэглэгч хоорондын хоёр чиглэлт (Two-way / P2P) харилцаанд ашиглах бөгөөд өөрсдийн сүлжээний дугаарлалтаас дараах төрлийн мессеж илгээхийг хориглоно. Үүнд:
- 4.4.2.1 Байгууллагаас хэрэглэгчид чиглэсэн үйлчилгээний болон мэдээ, мэдээлэл хүргэх мессеж (ОТР, 2FA зэрэг хэрэглэгч баталгаажуулах мессеж, төлбөр, гүйлгээний болон бусад төрлийн мэдээлэл, сануулга хүргэх, санал авах зорилготой мессеж гэх мэт);
- 4.4.2.2 Нэг болон олон хэрэглэгчид руу илгээж буй аливаа зар сурталчилгаа, маркетингийн шинжтэй мессеж болон масс мессеж;
- 4.4.3 Аль нэг тал хууль тогтоомжийн хүрээнд сүлжээний дугаарлалт шинээр үүсгэх тохиолдолд талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж баталснаас хойш ажлын 5 (тав) өдөрт багтаан нөгөө тал сүлжээндээ үүсгэнэ.
- 4.4.4 Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах үүрэгтэй.

ТАВ. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Зааглах цэгээс хоёр тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл саатлын засвар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 5.2. Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд аль болох ачаалал багатай өдөр, цагийг сонгох ба ажиллах хугацаа, горимыг хуанлийн долоо хоногийн өмнө албан бичиг болон цахим шуудангийн аль алинаар нь урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 5.3. Талууд харилцан холболтын ярианы өгөгдлүүд нь талуудын төлбөр тооцооны системд зөв ажиллаж байгаа талаар жил бүрийн эхний улиралд багтаан тест хийн баталгаажуулж протокол үйлдэж байна.
- 5.4. Аль нэг тал нь нөгөө талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нэн даруй нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 5.5. Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус гэмт хэргийн шинжтэй халдлага, дайралт (fraud, attack) зэрэгт өртөх тохиолдолд тухайн тал нь нөгөө талд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 5.6. Талууд өөрийн сүлжээгээр дамжиж буй ачааллын урсгалд байнгын хяналт тавьж, хуурамч дуудлага (Spoof call), дугаар хуурамчаар өөрчлөх (CLI spoofing), дуудлагын шинж чанар, чиглэлийг төхөөрөмж ашиглан нуух, өөрчилөх (SIM Box), хэвийн бус урт хугацааны дуудлага (Long call alerting), урсгалын хэмжээний гэнэтийн өсөлт (Traffic volume assurance), хууль тогтоомж, зохицуулалтын нөхцөл шаардлагыг зөрчсөн бусад дуудлага, мессеж (Telemarketing, Spam messaging гэх зэрэг)-ийн урсгал, бусад хууль бус, залилангийн шинжтэй үйл ажиллагааг

зөрчилтэй үйлдэл гэж үзэх бөгөөд түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллах ба ийм шинж чанартай дуудлага, мессежийг нөгөө талын сүлжээнд харилцан холболтын сувгаар дамжуулан төгсгөхгүй байна.

- 5.7. Талууд энэхүү гэрээний 5.6-д заасныг хэрэгжүүлээгүйгээс үүдэн зөрчилтэй дуудлага, мессеж нөгөө талын сүлжээнд илэрсэн гэж үзвэл зөрчил гаргасан хэрэглэгчийн дугаар, эсхүл дугааруудын хүрээнд нь өөрийн дотоод журамд заасны дагуу түр хязгаарлалт хийх, үйлчилгээг зогсоох болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.8. Талууд өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас харилцан холболт хийсэн болон холбогдсон тохиолдолд дээрх шаардлагыг хангаагүй тал нь үүссэн хохирлыг хариуцна.
- 5.9. Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг Хавсралт 5-д заасан байна.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

- 6.1. Талууд гэрээний 1.4-д заасан үйлчилгээнүүдийн харилцан холболтын төлбөрийг Хавсралт 4-т заасан дүнгээр сар бүр тооцоо нийлж төлнө.
- 6.2. Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдсэн байна.
- 6.3. Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг 1 (нэг) секундийн алхамтайгаар тооцно.
- 6.4. Талуудын төлбөр тооцоо хариуцсан ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 6 (зургаа) хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, хуанлийн 8 (найм) хоногт багтаан тооцоог Хавсралт 4-т заасан тарифын дагуу бичгээр хийж баталгаажуулна.
- 6.5. Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн +/-1%-иас хэтрээгүй бол талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн +/-1%-иас хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр 6.4-т заасан хугацаанд багтаан нийлж зөрүүг ажлын хэсэг байгуулан дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 6.6. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог 6.4-т заасан хугацаанаас хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан нийлж, илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба хүлээн авсан нэхэмжлэхийн дагуу төлбөр хариуцагч тал нь тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш ажлын 10 (арав) өдрийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг түүнд ноогдох НӨАТ-ын хамт төлнө.
- 6.7. Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 6.8. Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг Хавсралт 4-т заасан үйлчилгээний чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 6.9. Талуудын хариуцсан ажилтан, ажлын зохион байгуулалтад өөрчлөлт орох, техникийн саатал гарах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тооцоо нийлээгүй нь төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.10. Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь Хавсралт 3-т дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд талуудын холбох шугамаар орж ирсэн бүх ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 6.11. Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн 5 (тав) хувийг тус тусын талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 6.12. Аль нэг тал Хавсралт 4-т заасан өөрийн харилцан холболтын үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 (арав) өдрийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.13. Гэрээний 6.6-д заасны дагуу илүү төлөлттэй талдаа харилцан холболтын төлбөрийн нэхэмжлэхийг тухайн цаг хугацаанд гаргаагүй нь төлбөрийг шаардах эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

- 6.14. Талууд энэхүү гэрээ байгуулагдахас өмнө үүссэн төлбөр тооцоог тооцоо нийлэх актыг үндэслэн энэ гэрээний Хавсралт 4-т заасан үнэ тарифын дагуу бүрэн төлж барагдуулна.
- 6.15. Энэхүү гэрээнд заасан зөрчилтэй үйлдлийн улмаас арга хэмжээ авсан нь харилцна холболтын төлбөр төлөх болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛОО. ХҮСЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 7.1. Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 (арав) өдрийн дотор үүссэн талд гаргаж өгнө. Талууд энэхүү гэрээний дагуу олж авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 7.2. Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрд нь аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 7.3. Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө талын сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө талдаа тухай бүр ажлын 5 (тав) өдрийн өмнө мэдэгдэх ба хүлээж авсан тал ажлын цар хэмжээнээс хамааран гүйцэтгэх хугацааг тохирон хэрэгжүүлнэ. Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 7.4. Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ

- 8.1. Талууд гэрээ байгуулах болон хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан нөгөө талын бизнесийн болон хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (дотоод зохион байгуулалт, техникийн шийдэл, хамгаалалт, аюулгүй байдал гэх мэт)-ыг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол, эсвэл түүний эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар, бичгээр болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 8.1.1. Задруулах, олшруулах, түгээх;
- 8.1.2. Өөрт болон гуравдагч этгээдэд ашиг олох, давуу байдал тогтоох зорилгоор нууц мэдээллийг бусад байдлаар ашиглах.
- 8.2. “Нууц мэдээлэл” гэдэгт Талуудын хамтын ажиллагааны явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн, авсан, мэдэх болон авах боломжтой аливаа мэдээлэл, программ хангамж, биллинг систем, хэрэглэгчийн хувийн мэдээлэл (овог нэр, хаяг, бусад), бараа худалдах, тээвэрлэх, түгээх маршрут, үйл явц болон техник технологи (ноу-хау мөн хамаарна), компанийн бүтэц, зохион байгуулалт, төсөв, бизнес төлөвлөгөө, дүрэм, журам, зах зээлд гаргаагүй байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, гэрээ, хэлцэл, баримт материал, эх хувь болон хуулбар, ноорог, цахим хэлбэрээр дамжуулсан файл, аман хэлбэрээр уламжилсан мэдээ мэдээлэл, үйлчлүүлэгчийн зүгээс бусад гуравдагч этгээдтэй хийсэн аливаа хэлэлцээр, уулзалтын тов, хэлэлцэгдэж буй асуудлууд болон хамтын ажиллагааны хүрээнд үүссэн аливаа мэдээлэл, баримт бичиг, биет зүйлийг ойлгох бөгөөд эдгээр мэдээлэл нь бичгэн, цахим, аман аль ч хэлбэрээр байж болно.
- 8.3. Дараах нөхцөл байдал нотлогдсон тохиолдолд Талуудын мэдээллийн нууцлалыг хангах үүрэгт үл хамаарна:
- 8.3.1. Тухайн мэдээлэл олон нийтэд ил болсон;
- 8.3.2. Шүүх, хуулиар тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эсхүл хуульд заасны дагуу мэдээллийг нийтэд ил болгох, задруулах шаардлагатай болсон.
- 8.4. Энэхүү гэрээнд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аль нэг тал нь мэдээллийн нууцыг чанд хадгалах үүргээ биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, нууцыг задруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас нөгөө талдаа учирсан зардал, хохирлыг гэм буруутай тал бүрэн барагдуулна.

ЕС. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫГ ХЯЗГААРЛАХ, ТҮР САЛГАХ

- 9.1. Энэхүү гэрээгээр хийгдсэн сүлжээний харилцан холболтыг дараах тохиолдолд хязгаарлах болон түр салгаж болох ба энэ нөхцөлд 3.2.6-д заасныг баримтлана.
- 9.1.1. Аль нэг тал энэхүү гэрээний 5.6-д заасныг хэрэгжүүлээгүйгээс үүдэн 5.7-т заасан арга хэмжээ авсан ч 5.6-д заасан зөрчил үргэлжилсээр байх тохиолдолд нөгөө тал зөрчилтэй дугааруудад хязгаарлалт хийнэ.
- 9.1.2. Аль нэг тал 9.1.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хуанлийн 14 (арван дөрөв) хоногийн хугацаанд зөрчлийг арилгах талаар зохих арга хэмжээ аваагүй, эсхүл зөрчил үргэлжлэн давтагдсан тохиолдолд зөрчилтэй үйлчилгээ, маршрут, холболтын суваг, харилцан холболтын урсгалд хязгаарлалт тогтооно.
- 9.2. Энэхүү гэрээний 9.1.2-т заасан хязгаарлалтын арга хэмжээг авсан боловч тухайн зөрчил давтагдсаар байгаа тохиолдолд болон дараах тохиолдолд түр салгалт хийнэ. Үүнд:
- 9.2.1. Гэрээгээр тохиролцсон техникийн үзлэг, шалгалт хийхэд шаардлага хангаагүй бөгөөд уг зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй;
- 9.2.2. Харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бөгөөд төлбөрийн хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн;
- 9.2.3. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон.

АРАВ. ХАРИУЦЛАГА

- 10.1. Аль нэг тал нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан бодит хохирлоо буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.
- 10.2. Бодит хохирол гэдэгт үүргийн гүйцэтгэлийг хангахад гарсан зардал, учирсан гэмтэл, алдагдал, өмгөөлөгчийн хөлс, шүүх нотариатын зардал зэргийг ойлгоно.
- 10.3. Аль нэг тал энэ гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 10.4. Дор дурдсан нөхцөлд аль нэг тал нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.3 хувиар алданги тооцно. Үүнд:
- 10.4.1. Аль нэг тал 6 дугаар зүйлд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн;
- 10.4.2. Аль нэг талын аливаа алдаа эсвэл буруутай үйлдлээс шалтгаалж харилцан холболтын тооцоог 6 дугаар зүйлийн 6.4-т заасан хугацаанд багтаан нийлээгүйн улмаас 5 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу төлбөр төлөх хугацаа хойшилсон;
- 10.4.3. Аль нэг тал энэ гэрээ болон хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцан холболтын тооцоог нийлээгүй, нийлэхийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас харилцан тооцоо нийлэх хугацаа өнгөрсөн бол.
- 10.5. Талууд энэхүү гэрээний 13-р зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, түүнчлэн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй болно.

АРВАН НЭГ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 11.1. Энэхүү гэрээ нь дарах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 11.1.1. Гэрээний хугацаа дууссан бөгөөд талууд Гэрээний хугацааг сунгахгүй байхаар харилцан тохиролцсон;
- 11.1.2. Талууд харилцан тохиролцож эсхүл гэрээнд заасны дагуу аль нэг талын санаачилгаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан;
- 11.1.3. Аль нэг талын харилцан холболтын дагуу үзүүлж буй үндсэн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл дуусгавар болсон эсхүл хүчингүй болсон;
- 11.1.4. Аль нэг тал төлбөрийн чадамжгүй болсон нь нийтэд тодорхой болсон, эсхүл эрх бүхий байгууллагаас энэ тухай мэдэгдсэн;
- 11.1.5. Хууль болон гэрээнд заасан бусад үндэслэл;
- 11.2. Аль нэг тал гэрээний 9.2-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг шат дараатай хэрэглэж эхэлснээс хойш нөгөө тал хуанлийн 30 (гуч) хоногийн дотор гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 11.3. Гэрээний 9.4-т заасны дагуу хариуцлага тооцсон, эсхүл гэрээ дуусгавар болсон нь аль нэг тал нөгөө талын өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг (төлбөрийн үүрэг болон бусад холбогдох үүрэг), хариуцлага болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

АРВАН ХОЁР. МЭДЭГДЭЛ БАТАЛГАА

- 12.1. Талууд дараах мэдэгдэл баталгааг гаргаж байна. Үүнд:
- 12.1.1. Энэхүү гэрээг байгуулагдах өдрийн байдлаар энэхүү гэрээтэй холбоотой талуудын амаар болон бичгээр өгсөн аливаа мэдээлэл, баримт нь үнэн зөв, бүрэн болно.
 - 12.1.2. Энэхүү гэрээний дагуу хүлээсэн бүхий л үүргээ хэрэгжүүлэх хангалттай ур чадвар, туршлага, хүний нөөцийн, санхүүгийн болон техникийн чадвартай, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрхтэй ба уг зөвшөөрөл, эрх нь гэрээний хугацаанд хүчинтэй байна.
 - 12.1.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх болон бусад бүхий л үйл ажиллагаандаа харилцаа холбоо болон өрсөлдөөний холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажилладаг, ажиллах ба нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуун, ёс зүйн хэм хэмжээнд харшилсан, нөгөө талын нэр хүндэд харшлахуйц, үнэт зүйлд үл нийцсэн үйл ажиллагаа явуулахгүй.
 - 12.1.4. Гэрээний нөгөө талын ажилтан, эрх бүхий этгээдэд ямарваа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр үнэ бүхий зүйл, давуу байдал санал болгоогүй, амлаагүй, олгоогүй ба хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилттэй холбоотой шийдвэр гаргах явцад шударга бусаар нөлөөлөөгүй, холбогдох Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөж ажилладаг, ажиллах болно.
 - 12.1.5. Аль нэг тал, түүний ажилтан, эрх бүхий этгээд нь Олон Улсын болон Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг холбогдох хууль тогтоомжтой танилцсан, тэдгээрийг зөрчөөгүй, зөрчихгүй ба тэдгээрт нийцүүлэх үйл ажиллагаа явуулан, ийнхүү шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
 - 12.1.6. Энэхүү гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай бөгөөд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь Талуудын дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөлтэй зөрчилдөхгүй, аливаа гуравдагч этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй болно.
 - 12.1.7. Аль нэг тал нь нөгөө талын ажилтан болон эрх бүхий этгээдтэй гэр бүлийн харилцаагүй эсхүл бусад байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй, ийнхүү сонирхлын зөрчилтэй тохиолдолд энэ талаар урьдчилан мэдэгдсэн болно.
 - 12.1.8. Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхдээ өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээг баримталж, нөгөө талынхаа хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэж, хамгаалахад хамтарч ажиллана.
 - 12.1.9. 8.2. Энэхүү гэрээнд дурдсан хориглосон үйл ажиллагааг явуулах, тэдгээрийг санхүүжүүлэх, ивээн тэтгэхийг нөгөө талаасаа шаардах, санал болгох, тулгах, гарцаагүй байдалд оруулах, шантаажлах зэрэг эдгээртэй адилтгах аливаа хэлбэрээр нөгөө талдаа зүй бус нөлөөлөл үзүүлэхгүй.
- 12.2. Талууд энэхүү гэрээний дагуу гаргасан мэдэгдэл, баталгаанд өөрчлөлт орсон, эсхүл өөрчлөлт орох бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

АРВАН ГУРАВ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 13.1. Энэ гэрээний хугацаанд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй бол энэ талаар нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 13.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт гэрээний талуудаас хяналтаас гадуур урьдчилан таамаглах боломжгүй, талууд гэрээгээр хүлээх үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдлыг ойлгох бөгөөд үүнд байгалийн гамшиг, олон улсын шинжтэй хил боомт хаагдах, ажил хаялт, дайн, дайн бүхий байдал, өвчин тахал, хорио цээр, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг хамаарна.
- 13.3. Нэг талын буюу тухайн талын төлөөлөгч, ажилтны хайхрамжгүй байдал, санаатай үйлдлийн улмаас үүссэн аливаа үйл явдал нь 13.2-т заасан гэнэтийн буюу давагдашгүй зүйлд хамаарахгүй.
- 13.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын нөлөөнд өртсөн тал нь давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар, талуудын эд хөрөнгө, ажиллагсдын эрүүл мэндэд

учирч болох хохирлыг багасгах талаар шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй. Ийнхүү сайн дурын үндсэн дээр өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг авсан бол хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

- 13.5. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирол, нөхцөл байдлыг аль болох богино хугацаанд сэргээх ажлыг талууд тохиролцон авч хэрэгжүүлэх ба энэ үед тухайн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн, эрсдэлийг хуваарилах талаар тохиролцож болно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбогдуулан аль нэг талд зардал гарсан тохиолдолд уг зардлыг тухайн тал өөрийн хөрөнгөөр дангаар хариуцна.
- 13.6. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас Гэрээний хэрэгжилт хуанлийн 30 (гуч)-аас дээш хоногийн хугацаагаар бүхэлдээ буюу хэсэгчлэн саатсан тохиолдолд аль нэг тал нь нөгөө талдаа хандан Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтээ бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

АРВАН ДӨРӨВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 14.1. Гэрээтэй холбогдон үүсэж болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 14.2. ХХЗХ-ноос гаргасан шийдвэрийг маргалдагч талууд аль болох хүлээж авна. Хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй эсвэл ХХЗХ хуульд заасан хугацаанд шалгаж хариу өгөөгүй тохиолдолд талууд шүүхэд хандах эрхтэй.

АРВАН ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 15.1. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 15.2. **Гэрээний эх хувь:** Гэрээг Монгол хэл дээр 3 (гурван) эх хувь үйлдэж, тал тус бүр нэг нэг хувийг хадгалж, нэг хувийг ХХЗХ-нд бүртгүүлэхээр хүргүүлэх бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 15.3. **Хууль тогтоомж:** Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 15.4. **Нэмэлт өөрчлөлт:** Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно. Аль нэг тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талд бичгээр хүргүүлэх ба саналыг хүлээн авсан тал ажлын 3 (гурван) өдөрт багтаан хариу хүргэнэ.
- 15.5. **ХХЗХ-нд бүртгүүлэх:** Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 10 (арав) өдрийн дотор Юнител нь гэрээг хавсралтуудын хамт ХХЗХ-нд хүргүүлнэ. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг ХХЗХ-нд тухай бүр хүргүүлж байна.
- 15.6. **Гэрээний хүчин төгөлдөр байдал:**
- 15.6.1. Талуудын эрх бүхий төлөөлөгчид өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээнд заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 15.6.2. Энэхүү гэрээний аливаа зүйл заалт хууль тогтоомжид орсон өөрчлөлт, бусад байдлаас шалтгаалан хүчин төгөлдөр бусд тооцогдсон нь гэрээний бусад зүйл заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй. Энэ тохиолдолд талууд гэрээний тухайн заалтыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн өөрчлөх байдлаар гэрээг хэрэгжүүлнэ.
- 15.6.3. Гэрээний нууцлал, хариуцлага болон шаардах эрхтэй холбоотой заалтууд нь энэ гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр байдал нь хугацаагүй үргэлжилнэ.
- 15.7. **Гэрээний заалт хүчин төгөлдөр бус болох:** Хэрэв энэхүү Гэрээний аль нэг заалт хууль бус эсхүл хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй болох нь тогтоогдвол тухайн заалт нь хууль бус, хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй тухайн хүрээнийхээ хувьд хүчин төгөлдөр бус болно. Гэхдээ энэхүү Гэрээний бусад зүйл, заалтуудын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд хүчин төгөлдөр бус болсон заалтыг Талуудын тохиролцоонд үндэслэн өөр заалтаар эсхүл холбогдох хууль тогтоомжийн заалтаар орлуулан хэрэглэнэ.

- 15.8. **Эрх шилжүүлэх:** Энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол аль нэг тал нь нөгөө талынн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээний дагуу хүлээсэн эрх, үүргээ бүтнээр болон хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 15.9. **Талууд харилцах:** Талууд нэг нэгэндээ хандан гаргасан аливаа мэдэгдлийг цахим болон бичгийн хэлбэрээр Хавсралт 5-т заасан албан хаягийн дагуу илгээнэ. Аль нэгт тал нь энд заасан албан хаягийн мэдээлэлд өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 5 (тав) өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:

[•] **ХХК:**
[•]

Юнител ХХК:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 8 давхар

Регистрийн дугаар: [•]
Утас: [•]

Регистрийн дугаар: 5036895
Утас: 7777 8080

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

[•] **ХХК-ийг төлөөлж:**

Юнител ХХК-ийг төлөөлж:

.....
[•]
Гүйцэтгэх захирал

.....
[•]
Гүйцэтгэх захирал

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Юнител	[•]	Тайлбар
Холболтын байгууламжийн төрөл, марк	SE2980 UMG8900	*****	*****
Дамжуулах байгууламжийн төрөл, марк	NE8000, MPLS Router	*****	*****
Холбох шугамын төрөл, марк, тоо	20Gb	*****	*****
Интерфейсийн төрөл	STM-1, GE, 10GE	*****	*****
Дамжууллын протокол (IP холболт)	TLS/SRTP	TLS/SRTP	*****
Бусад	-	-	-

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил	Тайлбар
Зааглах цэг 1-ийн байршил	*****	*****
Тоног төхөөрөмж	*****	*****
Ашиглалт үйлчилгээг хариуцах	Зааглах цэгээс хоёр тийш өөрийн талын тоног төхөөрөмж, шугамын ашиглалт үйлчилгээг талууд өөрсдөө хариуцна.	

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

[•] ХХК-ийг төлөөлж:

Юнител ХХК-ийг төлөөлж:

.....
 [•]
 [•]

.....
 [•]

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

[•] ХХК-ийг төлөөлж:

Юнител ХХК-ийг төлөөлж:

.....
[•]

[•]

.....
[•]

ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Юнителийн сүлжээний дугаарлалт

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	

[•]-ийн сүлжээний дугаарлалт

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

[•] ХХК-ийг төлөөлж:

Юнител ХХК-ийг төлөөлж:

.....
 [•]

.....
 [•]

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

Хот, хот хоорондын ярианы харилцан холболтын үнэ тариф

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	[•]	Юнител

Улс хоорондын яриа харилцан холболтын үнэ тариф

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	[•]	Юнител

Тайлбар:

- * [•] ХХК-ийн тухайн үйлчилгээний тариф
- ** Юнителийн тухайн үйлчилгээний тариф
- *** Юнителийн хэрэглэгч [•] ийн улс хоорондын ярианы урьдчилсан төлбөрт карт ашиглах тохиолдолд нь картаасаа орлогоо тооцож авна.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

[•] ХХК-ийг төлөөлж:

Юнител ХХК-ийг төлөөлж:

.....
 [•]

.....
 [•]

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

[•] ХХК-ийн албан тушаалтан, холбоо барих хэрэгсэл

Ажлын чиглэл	Алба, хэлтэс	Албан тушаал	Албан тушаалтны нэр, холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

Юнител ХХК-ийн албан тушаалтан, холбоо барих хэрэгсэл

Гэрээний асуудлаар болон сүлжээний дугаарлалттай холбоотой асуудлаар	Эрсдэлийн удирдлага, комплаенсийн газар	Газрын захирал	
Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх техникийн өргөтгөл, өөрчлөлттэй холбоотой асуудлаар	Техникийн газар	Инженер	
Гэмтэл саатал болон техниктэй холбоотой яаралтай асуудлаар	Техникийн газар	Ээлжийн инженер (24 цаг)	
Төлбөр тооцооны асуудлаар	Мэдээллийн технологийн алба, Төлбөр тооцооны хэлтэс	Биллинг инженер	
	Санхүүгийн алба, Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	Нягтлан бодогч	

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

[•] ХХК-ийг төлөөлж:

Юнител ХХК-ийг төлөөлж:

[•]

[•]

Гүйцэтгэх захирал